

Дабстэп

Вася Берландын хамгийн шилдэг шөнийн клубт ажилладаг бөгөөд, өөрийн тоглолтондоо Дабстэп хөгжмийг голдуу ашигладаг гэнэ. Тэр саяхан хэд хэдэн хуучны дуунуудыг нийлүүлж дабстэп микс хийхээр шийджээ.

Дуу нь хэд хэдэн үгнээс тогтдог гэж үзье. Тэрбээр дараах байдлаар микс хийдэг. Хамгийн эхний үгийн урд хэд хэдэн (байхгүй ч байж болно) "WUB" гэсэн үгийг, сүүлийн үгийн хойно мөн хэд хэдэн "WUB"-г, мөн үг бүрийн дунд ядаж "WUB" гэсэн үгийг нэмдэг. Ингээд тэр шинэ үүссэн дуугаа клубтээ тоглодог ажээ.

Жишээ нь "I AM X" гэсэн үгтэй дуу "WUBWUBIWUBAMWUBWUBX" гэсэн дабстэп микс болох бөгөөд харин "WUBWUBIAMWUBX" болохгүй.

Петя Васягийн шинэ дууг сонсоод, орчин үеийн дуунд тийм ч дуртай биш болохоороо анхны дуу нь ямар байсныг мэдэхийг хүссэн. Түүнд туслаарай!

Input

Оролтонд латин цагаан толгойн том үсгүүдээс тогтох, хоосон биш тэмдэгт мөр өгөгдөнө. Уг тэмдэгт мөрийн урт 220 тэмдэгтээс хэтрэхгүй. Вася дуунд микс хийхээс өмнө "WUB" гэдэг үг огт байгаагүй. Мөн Вася үгнүүдийг дарааллыг нь сольдоггүй. Мөн дуу анх ядаж ганц үгтэй байсан болно.

Output

Анхны дууны үгнүүдийг дарааллаар нь хэвлэнэ үү. Үгүүдийг хооронд нь хоосон зайгаар салга.

Example

Input 1:

WUBWUBABCWUB

Output 1:

ABC

Input 2:

WUBWEWUBAREWUBWUBTHEWUBCHAMPIONSWUBMYWUBFRIENDWUB

Output 2:

WE ARE THE CHAMPIONS MY FRIEND